“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ”
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай
компани




# КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022.12.15

"Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Япон, Монголын хамтарсан хуулийн этгээдийн Монголын талын төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлж, ашигтай ажиллагааг хангах. "Чингис хаан" Олон улсын нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг тогтворжуулахад үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаа.

Компанийн бизнес төлөвлөгөө

2022 он

31 ажил, арга хэмжээ

Монголын талын Хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх

Монгол талын Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх

- Хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг холбогдох эрхзүйн хэм хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх
- Компанийн тогтвортой хөгжлийг хангах
- Компанийн дотоод зохион байгуулалт, засаглалыг сайжруулах
- Санхүүгийн ил тод байдлыг хангах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөх





Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон компанийн үйл ажиллагаа 2022 оны бизнес төлөвлөгөө амжилттай хэрэгжсэн.

## "ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ" ТӨХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

2018 он 150 дугаар тогтоол

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

**66%**

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**34%**

Компанийн тухай хууль, дүрмийн дагуу "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг 1, ээлжит бус хурлыг 2 удаа тус тус зохион байгуулж, 5 тогтоол гарч, хэрэгжилт 100 хувьтай байна.

**1**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

**3 удаа**

- 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан;
- 2022 оны бизнес төлөвлөгөө;
- 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт;
- 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын шинэчлэлт;
- Компанийн дүрмийн өөрчлөлт.

## "НЬЮ УЛААНБААТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

**"ЖАПАН ЭЙРПОРТ МЕНЕЖМЕНТ" ХХК**

**51%**

**"ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ" ТӨХХК**

**49%**

Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчийн гэрээний дагуу "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг 1, ээлжит бус хурлыг 1 удаа тус тус зохион байгуулж, 3 тогтоол гарч, хэрэгжилт 100 хувьтай байна.

**2**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ**

**2 удаа**

- Гүйцэтгэх захирал Такео Катог ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх;
- Гүйцэтгэх захирал Китанака Такефумиг ТУЗ-ийн гишүүнээс томилох;
- 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бүтэц, хөрөнгийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт.

**Монгол, Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Монголын талын төрийн мэдлийн 49 хувийн Хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд**



"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-д Монголын талын төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүдийн баримтлах 9 (2022.02.14, 2022.03.02, 2022.03.22, 2022.07.07, 2022.08-17, 2022.11.10, 2022.11.23, 2022.12.13) удаагийн удирдамж, чиглэлийг хүргүүлж, батлагдсан удирдамж, чиглэлийн дагуу холбогдох 13 тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргуулаа

Хөдөлмөрийн тухай хуулийн аливаа нөхцөл, шаардлагад нийцүүлэн байгуулах
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, бүтэц, хөрөнгийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах;
- Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг чөлөөлөх, томилох
- "Чингис хаан" олон улсын нисэх буудалд үүсээд буй бөөгнөрлийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээ зэргийг дүгнэсэн Ажлын хэсгийн тайланд тусгагдсан ажлуудын талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах
- Ачаа тээшний хоёр ширхэг туузан дамжуурга (А болон В)-ыг уртасгах тухай гэрээг байгуулах, холбогдох ажил, гэрээг гүйцэтгэх, гэрээт ажлын хэрэгжилт, бөөгнөрөлтэй холбоотойгоор нисэх буудалд гарсан үр дүнгийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөл-д тайлагнах гэх мэт

- Нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах
- Нисэх буудлын үйл ажиллагаа, зорчигчдын бөөгнөрөл, тулгамдаж буй асуудал
- "Чингис хаан" олон улсын нисэх буудлын Мастер төлөвлөгөөг гаргах
- Концессын гэрээний дагуу ногдол ашгаас чөлөөлөх тухай

**3**

**ХАМТАРСАН УУЛЗАЛТ, ХУРАЛ**

**51** **удаа**

NUBIA

Нисэх буудлын үйлчилгээг сайжруулах ажлын төлөвлөгөө

Олон улсын явах нислэгийн зорчигч урсгалын бөөгнөрлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө

Үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний чанарыг дэлхийн түвшинд хүргэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх

Япон улсад хэрэгжиж буй үйлчилгээний соёлыг шинэ нисэх буудалд дэлгэрүүлэх

CHINGGIS KHAAN INTERNATIONAL AIRPORT

***"Чингис хаан" олон улсын нисэх буудалд үүсээд буй бөөгнөрлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, цаашид бөөгнөрлөөс сэргийлж нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зохион байгуулалтыг авч ажилласан.***

Монгол Улсын Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 228 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн яамнаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу "Чингис хаан" Олон улсын нисэх буудалд үүсээд буй бөөгнөрлийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, цаашид бөөгнөрлөөс сэргийлж нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, Концессын зүйлийг сайжруулах боломжтой арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах зорилгоор "Хэшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК, "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн захирлын хамтарсан А/11, А14 тоот тушаалаар ажлын хэсгийг байгууллаа.

Ажлын хэсгийн тайлан болон концессын төлбөрийг тээзэн дамжуургыг өргөтгөх, сунгах шаардлагатай санхүүжүүлэлтэд шилжүүлэх саналыг Зам, тээврийн хөгжлийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**
**САНГИЙН ЯАМ**









Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн 2021 оны Концессын төлбөр болох **1,193,453,849** төгрөгийг ачаа, тээшний тээзэн дамжуургын 2 төхөөрөмжийг уртасгаж хүчин чадлыг сайжруулахад зарцуулж, үйлдвэрлэгчид тээзэн дамжуургыг захиалах, угсарч суурилуулах, худалдан авах ажиллагааг эхлүүлэхээр болсон.

"Чингис хаан" олон улсын шинэ нисэх буудлын "Өвлийн цагийн хуваарь"-ийг батлуулахад "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн саналыг тусгах талаар Зам, тээврийн хөгжлийн яам болон Иргэний нисэхийн ерөнхий газарт танилцуулан нэг цагт хүлээн авах агаарын хөлөг, зорчигчдын тоог нисэх буудлын бодит хүчин чадалд нийцүүлэх замаар Туркиш авиа компанийн Мягмар гарагийн нислэгийг 30 минутаар, Аэромонгол компанийн 1,3,5 өдрийн нислэгийг 1 цаг 30 минутаар хойшлуулах зохицуулалт хийсэн. Мөн өвлийн хуваарьт Аэрофлот /Москва/ болон Изинис компанийн /Хонконг/ чиглэлийн нислэг шинээр нэмэгдсэн.

Цагийн зохицуулалт **30** минутаас **1** цаг **30** минут

**Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр нисэх буудлын ачааллалтай үед 1 цагт авах Олон улсын зорчигчийн тоог 920 зорчигчоос 1220 зорчигч хүртэл өсөх боломжтой гэж тогтсон.**





"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн "Хэрэглэгчид үйлчлэх зөвлөл", үйлдвэрчний эвлэлийн хорооны хуралд компанийн төлөөллийг оролцуулж, ажилтан, зорчигч, үйлчилгээнд тулгарч буй асуудал, хэрэглэгчдээс ирүүлсэн санал хүсэлтүүд, цаашид авах арга хэмжээ, анхаарах асуудлын талаар 3 удаа санал, зөвлөмж өгч ажиллав.

Монгол Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Като Такэогийн ажиллах хугацаа дуусаж, гүйцэтгэх захирлаар шинээр томилогдсон Китанака Такэфумиг 2022 оны 04 дүгээр сард Хувьцаа эзэмшигчдийн SHR-02/2022 тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилов.



Хувьцаа эзэмшигчийн зүгээс "Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг амжилттай эхлүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлэн Като Такэог Зам, тээврийн хөгжлийн яамны "Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан"-аар шагнуулав.



"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудлын орон нутгийн нислэгийн 2018-2021 оны нээлттэй тоон мэдээлэл, "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн 2022 оны тоон мэдээлэл 2022-2024 оны төсөөлөл, бодит нөхцөл байдал зэрэгт үндэслэн "Орон нутгийн нислэгийн орлого зардал ашиг алдагдал"-ын тооцоо судалгааг тогтмол хийж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.







Ковид-19 цар тахлын өмнөх түвшинтэй харьцуулахад олон улсын зорчигчийн тоо 47%, орон нутгийн зорчигчийн тоо 78%-тай тус тус сэргэсэн үзүүлэлттэй байна.

| | | 2019 оны бодит гүйцэтгэл | 2022 оны хүлээлт | 2023 оны төлөвлөгөө | 2024 оны төлөвлөгөө | 2025 оны төлөвлөгөө |
|---|---|---|---|---|---|---|
| Олон улс | Зорчигч | 1,196,213 | 605,355 | 912,610 | 1,183,493 | 1,231,391 |
| | Нислэг | 10,101 | 5,002 | 6,583 | 9,876 | 10,606 |
| Орон нутаг | Зорчигч | 414,804 | 329,082 | 385,110 | 362,321 | 369,764 |
| | Нислэг | 6,355 | 4,251 | 6,145 | 4,370 | 4,671 |

"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн эрэлтийн урьдчилсан төсөөлөлд олон улсын зорчигч 2024 онд, орон нутгийн зорчигч 2023 онд "Ковид-19"-ийн өмнөх түвшинд хүрнэ гэж үзэж байна.

***Агаарын тээврийн болон Нисэх буудлуудын үйлчилгээний талаарх Дэлхий дахины ирээдүйн чиг хандлага, "Чингис хаан" олон улсын нисэх буудлын өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой судалгаа, дүн шинжилгээ хийж Зам, тээврийн хөгжлийн яаманд танилцуулав.***

2025 онд Дэлхийн агаарын тээврийн Олон улсын зорчигчдын сэргэлт Ковид-19-ээс өмнөх үеийнхтэй харьцуулахад +1% байна гэсэн таамаглал дэвшүүлсэн. Эдийн засгийн сэргэлт удаашралтай, бусад нөхцөл байдлын улмаас Ази Номхон далайн бүсийн зорчигчдын тоо нэмэгдэхгүй гэж тооцоолжээ.





**Олон улсын нисэх буудлуудын зөвлөл /ACI/** 2040 онд Улс хоорондын агаарын тээвэр 64% байхаар тооцоолсон. (2019 онд: 71%) Ази Номхон далайн орнуудын зорчигч тээврийн зах зээлийн хувь хэмжээ 2019 онд 36.9% байсан бол 2040 онд 45.0% болж нэмэгдэнэ.






## ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРЫН ЦААШИД ЧИГ ХАНДЛАГА

| Чиглэл | 2019 | 2021 (дээд боломж) | 2022 (дээд боломж) | 2023 (дээд боломж) | 2024 (дээд боломж) |
|---|---|---|---|---|---|
| [illegible] | 7,020 | 8,732 | 10,010 | 11,284 | 13,146 |
| Токио /7 хоног/ | 2,720 | 2,720 | 3,376 | 4,080 | 4,760 |
| Хонконг /7 хоног/ | 2,380 | 3,340 | 2,872 | 3,604 | 3,740 |
| Бээжин /7 хоног/ | 4,080 | 4,080 | 3,808 | 4,760 | 4,760 |
| Москва /7 хоног/ | 1,320 | 1,020 | 3,016 | 2,830 | 3,528 |
| Франкфурт /7 хоног/ | 7,080 | 3,010 | 2,520 | 3,624 | 3,628 |
| Нийт /7 хоног/ | 19,352 | 21,008 | 24,708 | 28,306 | 33,462 |
| Жилийн дүн | 1.1 сая | 1.4 сая | 1.5 сая | 2 сая | 2.2 сая |

| [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] | [illegible] |
|---|---|---|---|---|---|
| [illegible] | [illegible] | 1 | 1 | 1 | 1 |
| [illegible] | | | 1 | 1 | 1 |
| [illegible] | 4 | 4 | 4 | 4 | 5 |
| Нийт | 5 | 5 | 6 | 5 | 7 |

***"Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-д зөвлөмж, дэмжлэг үзүүлж ажиллав.***

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгөгдсөн үүрэг даалгавар, Компанийн ТУЗ-ын хурал, хурлын тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах;

Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан үзлэг шалгалт, хурал, уулзалтад тухай бүр оролцож, санал, дүгнэлтээ танилцуулах;

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ажилтны үйлдвэрчний эвлэлийн хороо, Монголын тээвэр холбоо, газрын тосны Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос гаргасан гомдлыг шийдвэрлэх;

"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгын 1 давхрын ирэгчдийн танхимын ачаа, тээшний хоёр туузан А ба В ременийг 36.5- 60.5 метр болгон уртасгах ажлыг эхлүүлэх;

Концессын гэрээний 19 дүгээр зүйлийн дагуу "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Концессын 15 жилийн хугацаа буюу 2035 он хүртэлх хугацааны Мастер төлөвлөгөө боловсруулах.

"Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудлын гадаа орчны цэвэрлэгээ болон ард иргэдэд чирэгдэл учруулж буй асуудлыг холбогдох байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх;

"Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг сайжруулах, зорчигчдын хил, гаалийн хяналтыг түргэн шуурхай болгох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, иргэдэд хүндрэл бэрхшээл үүсгэхгүй байх;

"Аэромонголиа" ХХК-ийн EMB-145LR, JU-1800 агаарын хөлгийн дугуйны резин хөөрөлтийн үеэр задарч, хагарсан асуудлыг шийдвэрлэх;

Нийтийн тээврийн зорчих 64 дүгээр зам буюу нисэх буудал руу зүүн талаас нэвтрэх автозамын хэсгээр мал, амьтад нэвтрэн, нисэх буудлын хязгаарлалттай бүс болох олон нийтийн хэсэгт бэлчиж, орчныг бохирдуулж асуудлыг зогсоох арга хэмжээ авах;

**15 зөвлөмж, чиглэл**
хүргүүлж, хэрэгжүүлэв.



Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт "Чингис хаан" олон улсын нисэх буудлын үйлчилгээ, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулж, тодорхой үүрэг чиглэл авч ажилласан.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооноос 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан уулзалтад "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК, "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-иас "Чингис хаан" олон улсын нисэх буудлын ашиглалтын байдал, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар танилцуулга хийв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Япон улсад хийх албан ёсны айлчлалын үеэр Монгол Японы хамтарсан "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-ийн Япон талын 51 хувийн хувьцаа эзэмшигчидтэй "Хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг үйлдэхэд Зам, тээврийн хөгжлийн яамны зүгээс дэмжлэг хүссэн тухай 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/170 тоот албан бичгийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод хүргүүлж, танилцуулсан.



Монгол Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-ийн Монголын Засгийн газрын 49 хувийн Хувьцаа эзэмшигчийн хувьд Концессын гэрээний 19 дүгээр зүйлийн дагуу "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Концессын 15 жилийн хугацаа буюу 2035 он хүртэлх хугацааны Мастер төлөвлөгөөний ажлын даалгаврыг батлуулж, 2023 оны 7 дугаар сард багтаан боловсруулахаар болсон.

"Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК ийн 2022 оны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, 2023 оны бизнес төлөвлөгөө, төсвийн эхний төслийг хянаж ажиллаж байна.

**ҮР ДҮН**

**Хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлж, Монголын талын хөрөнгө оруулалтыг оновчтой, зөв зарцуулах хяналтыг байнга тавьж ажилласнаар нисэх буудлын ашигт ажиллагаа нэмэгдсэн.**

**Төрийн хүндэт зочны танхимын үйлчилгээний хүрээнд**



## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
## ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

**"Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам"**

"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Хүндэт зочны танхимд 5470 зорчигч, угтагч үдэн гаргагчийг хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн.

**/2022.12.04-ний өдрийн байдлаар/**

## ГАДААД УЛСААС МОНГОЛ УЛСАД ХИЙХ ТӨРИЙН ӨНДӨР ХЭМЖЭЭНИЙ АЙЛЧЛАЛ

- ✓ Польш Улсын Гадаад хэргийн сайд З.Рау
- ✓ ОХУ-ын Гадаад Хэргийн Сайд С.В.Лавров
- ✓ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн зөвлөлийн гишүүн Гадаад хэргийн сайд Ван И
- ✓ НҮБ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш
- ✓ Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэргийн сайд Пак Жин
- ✓ ОХУ-ын Роснефть НХН-ийн Ерөнхий гүйцэтгэх захирал И.И.Сечин
- ✓ БНАЛАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд Салемсай Гуммасит,
- ✓ БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жаньшу;
- ✓ Унгар Улсын парламентын дарга Ласло Кевэр
- ✓ Канад Улсын Парламентийн Сенатын танхимын дарга Жорж Ж.Фьюри.
- ✓ Тайландын хаант улсын шадар сайд бөгөөд Хуулдааны сайд Журин Лаксанависит

## МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД ХИЙХ АЙЛЧЛАЛ

- ✓ ОХУ-ын Владивосток хотод болсон Олон улсын чуулга уулзалт
- ✓ Узбекистан улсын Ташкент хотод болсон Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын хурал
- ✓ ИБУИНХУ-ын Цог жавхлант Хатан хаан Хоёрдугаар Элизабеттай салах ёс гүйцэтгэх ёслол
- ✓ АНУ-ын Нью-Йорк хотод болсон НҮБ-ын чуулга, уулзалт
- ✓ Япон Улсын Ерөнхий сайд асан Ш.Абэтай салах ёс гүйцэтгэх ёслол
- ✓ Монгол Улсын Ерөнхий сайд ХБНГУ, БНТУ, Египет-д айлчлал
- ✓ Монгол Улсын Их хурлын дарга Г.Занданшатар БНТурк Улсад албан айлчлал
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Египет улс дахь айлчлал
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНХАУ болон Япон улсад хийсэн айлчлал







***Төрийн хүндэт зочны үйлчилгээ явуулах нөхцөлийг бүрдүүлж, үзлэг, шалгалт, ариутгалыг тогтмол хийлгэлээ.***

Гал, түймэр, гэнэтийн осол, зөрчил болон бусад эрсдэлт хүчин зүйлс бий болохоос урьдчилан сэргийлэх үүднээс авран хамгаалах, галын хор болон бусад цахилгааны хэрэгсэл зэрэгт үзлэг шалгалт хийлгэн, Аюулгүй байдал, хамгаалалтын албатай хамтран өглөө, орой бүр тогтмол шалгалт хийлгэв.

"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Шуурхай удирдлагын төвийн 71287300 утсаар зөлжийн ажиллагсад, захиалгын талаарх мэдээллийг тогтмол өгч, техникийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллав.















"Чингис хаан" олон улсын нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй "Хүндэт зочны танхим"-ийн галын дүгнэлт, тохирлын гэрчилгээ, өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг холбогдох байгууллагуудаар сунгуулав.

Үйлчлүүлэгч болон ажилтнуудын биеийн дулааныг суурин, зайнаас хэмжигч 2 төхөөрөмжөөр тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтлөн, гарын ариутгалын бодис, 1 удаагийн амны хаалт байрлуулж, зорчигчгүй үедээ танхимын агаар болон хатуу гадаргууг манананцар үүсгэгч төхөөрөмжөөр ариутган, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, хадваргүйжүүлэлтийг тогтсон хугацаанд хийж стандарт, норм журмын дагуу эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан.

"Чингис хаан" олон улсын нисэх буудал дахь Төрийн хүндэт зочны танхимын гадна зам, талбайн цэвэрлэгээ, ногоон байгууламжийн арчилгааны хуваарь"-ийг гарган, хуваарийн дагуу компанийн оффисын ажилтнууд сард нэг удаа гадна талбайн цэвэрлэгээг, Хүндэт зочны үйлчилгээний албаны ажилтнууд сард нэг удаа гадна, дотор талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалыг, үйлчилгээний туслах ажилтан долоо хоног бүрийн Даваа гаригт гадна талбайн зам, цэвэрлэгээг хийж хэвшсэн.

**ҮР ДҮН**

***Хүндэт зочны танхмын үйлчилгээг журмын дагуу амжилттай зохион байгуулж, зөрчил, дутагдалгүй ажилласан.***

## Компанийн засаглалыг сайжруулах ажлын хүрээнд

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар "Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө"-г хэлэлцэн батлуулж, хэрэгжүүлсэн.

**Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө**

- ✓ Хамтарсан хуулийн этгээдийн төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн эрх үүргийг холбогдох эрхзүйн хэм хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх
- ✓ Компанийн тогтвортой хөгжлийг хангах
- ✓ Санхүүгийн ил тод байдлыг хангах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөх
- ✓ Компанийн дотоод зохион байгуулалт, засаглалыг сайжруулах

*31 ажил, арга хэмжээ*

Үүнээс:
- Хэрэгжсэн ажил, арга хэмжээ **23**
- Хэрэгжих боломжгүй ажил, арга хэмжээ **5**

**100 хувь**

**Хэрэгжих боломжгүй ажил, шалтгаан**

- Хамтарсан компанид эзэмшүүлснээс бусад компанийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр нисэхийн болон нисэхийн бус үйл ажиллагааг тогтвортой ашигтайгаар явуулах, үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх
- УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хүрээнд гадны болон Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Нисэх буудал, аэродромын төсөл арга хэмжээнд зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх
- Гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын хүрээнд хэрэгжих Нисэх буудлын төсөл, арга хэмжээнүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлсний оновчтой системийг нэвтрүүлэх
- Мөнгөн бус урамшууллын бүхий л хэлбэрийг бий болгох

Шалтгаан

Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх боломжгүй болсон.

## 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Төсвийн хэмнэлтийн төлөвлөгөөний дагуу төсөв, зардлыг хэмнэх
- Хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Ковид -19 цар тахлын нөлөөллийг бууруулах
- Нисэх буудлын үйл ажиллагааг тогтвортой явуулах

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Зам тээврийн хөгжлийн сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2022 оны биелэлтийг сар, улирал, хагас жил, жилийн байдлаар тус тус гаргаж, Авлигатай тэмцэх газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус тус хүргүүлж, тайлагнав.

**100 %**

| | |
|---|---|
| Хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, тушаалын үүрэг, даалгавар | 41 үүрэг, даалгавар |
| ЗТХСайдын шуурхай хурал | 39 үүрэг, даалгавар |
| Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө | 13 ажил, арга хэмжээ |
| Нийтийн мэдээллийн ил тод байдал | 30 ажил, арга хэмжээ |
| Төсвийн хэмнэлтийн төлөвлөгөө | 8 ажил, арга хэмжээ |
| Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах арга хэмжээний төлөвлөгөө | 6 ажил, арга хэмжээ |
| Тэрбум мод үндэсний хөдөлгөөн | 6 ажил, арга хэмжээ |
| Санхүүгийн аудит, шилэн данс | Долоо, сар, улирал бүр |



"Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/50 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, өргөдөл, гомдол хариуцсан ажилтныг томилон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 2022 онд ирүүлсэн 6 хүсэлтийг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэв.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/214 тоот тушаалын хэрэгжилтийг хангаж, 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажил бүрэн 100 хувьтай хангагдсан.



Шинэ сэргэлтийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" ТӨХХК, "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК-иас 2024 он хүртэл хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, танилцуулав.

***Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангаж, ажилтан нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн ажиллаа.***



Тушаал 41

АЛБАН БИЧИГ 326

Ажиллаж буй хүний нөөц 28 68,2%

5 17,8%

Сургалт / танхим 5 17,8 %

Цахим сургалт 26 100 %

Хайлаас 300 2 удаа

Ковид -19 тун 28 100 %

ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬ
2022.01.01

- Ковид-19
- Шуурхай хурал




Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдэн 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжсэнтэй холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг шинэчилж, мөрдсөн.

"Ажлын гүйцэтгэлийг төлөвлөх, тайлагнах, дүгнэх журам"-ыг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/10 тоот тушаалаар шинэчлэн баталж, хэрэгжүүлсэн.

Хэлтсүүд ажлаа сар, улирал, жилээр төлөвлөн төлөвлөгөөний хэрэгжилтийг сар, улирлаар дүгнэснээр ажилчдын ажлын бүтээмж, сахилга хариуцлага дээшилж, байгууллагын төлөвлөсөн ажлууд цаг тухайдаа хэрэгжсэн

Ажилтнуудын ажлыг сар, улирал, жилээр дүгнэж, ажлын бүтээмжид нийцсэн цалин, хөлсийг олгосон.

"Захирлын шуурхай хурал"-ыг 2022 онд 8 удаа зохион байгуулж, 39 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангууллаа.

**Хэрэгжилт 100 %**

Компанийн ажилтнуудын ажил үүргийн хувиарлалт, ажил амралтын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөв.



Ажлын цаг

**8.00- 17.00**

Үдийн цайны завсарлага

**12.00-13.00** цаг

- ✓ Нийслэлийн автозамын хөдөлгөөний ачаалал
- ✓ Ажилтнуудын гаргасан санал, хүсэлт

***НИЙТЭЭР АМРАХЫН БАЯРЫН ӨДРҮҮД БОЛОН ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРГИЙН ҮЕД ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛ, ЖИЖҮҮРИЙГ ТОМИЛОН АЖИЛЛУУЛЛАА.***

ҮНДЭСНИЙ БАЯР НААДАМ
САР ШИНИЙН БАЯР
ШИНЭ ЖИЛИЙН БАЯР
КОВИД-19

→ **24** цаг

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ШУУРХАЙ ШТАБ

**51-263179**

Гүйцэтгэсэн үүрэг, чиглэл:

Байгууллагын өмч, хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, галын аюулгүй байдал, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж, Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцлагатай жижүүртэй тогтмол холбоотой ажиллаж, мэдээ, мэдээлэл солилцож ажилласан.

**"Зөрчил, дутагдалгүй"**

Компанийн үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, зохицуулах, журамлах, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧИГ** буюу нийт **40** тушаал, шийдвэрийг гаргаж, хэрэгжүүлж ажиллаа.

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 11

Хүний нөөцийн чиглэлээр- 29



Танилцуулга -3

Төлөвлөгөө, хөтөлбөр-7

## ХҮНИЙ НӨӨЦ



***Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ХЭХТ 21-05 тогтоолоор батлагдсан 41 ажилтны орон тооноос 68,9 хувь нь ажиллаж байна.***

**2021**

**АЖИЛЛАЖ БУЙ ХҮНИЙ НӨӨЦ**

28 АЖИЛТАН

2 нэгж буюу **7.14%**

**ШИНЭЭР ТОМИЛОГДСОН**

6 АЖИЛТАН

10 нэгж буюу **62.6%**

**АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН**

5 АЖИЛТАН

**0 %**

**ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ӨГСӨН**

5 АЖИЛТАН 7 УДАА

**ЦАХИМ СУРГАЛТ**

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулав.



**Цахим**

***5 БҮЛЭГ***
***26 сэдэвт***

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй
- Эрүүл мэндийн боловсрол
- Амьдрах ухаан
- Ажлын байрны дасан хөвөлгөөн
- Санхүүгийн мэдлэг

## Коронавирус (КОВИД-19)




Короновируст халдварын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үйлчлүүлэгч болон ажилтнуудын биеийн дулааныг суурин, зайнаас хэмжигч 2 төхөөрөмжөөр тогтмол хэмжиж, тэмдэглэл хөтлөн, танхимын агаар болон хатуу гадаргууг мананцар үүсгэгч төхөөрөмжөөр ариутган, цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж стандарт, норм журмын дагуу эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажилласан

### Урьдчилан сэргийлэх арга хэмжээ





**2324**
Ширхэг бараа материал

**1,743,126**
Нийт худалдан авалт /төгрөг/

Түргэвчилсэн шинжилгээ
**14** хоног тутам

***100%*** *(27 ажилтан*

### Вакцинжуулалтын явц



| | | |
|---|---|---|
| Эхний тун | ***100%*** | 27 ажилтан |
| Давтан тун | ***100%*** | 27 ажилтан |
| Гуравдугаар тун | ***81,48%*** | 22 ажилтан |
| Дөрөвдүгээр тун | ***3,70%*** | 1 ажилтан |

### Корона вирусын мэдээ, мэдээлэл

Шуурхай байдлыг хангах Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хурал, яамны дэргэдэх шуурхай штабын үйл ажиллагаанд байнга мэдээ, мэдээлэл харилцан солилцож ажилласан.

## Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах

| | | |
|---|---|---|
| Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэг | | 27 ажилтан ***93%*** |
| Үйлчилгээний ажилтны үзлэг, шинжилгээ | ***6 сар тутам*** | 14 ажилтан ***100%*** |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа | ***Сар, улирал тутам*** | 28 ажилтан ***100%*** |

## ЦАХИМ ШИЛЖИЛТ













Компанийн цахим хуудаст "Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт" ХХК, "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын талаарх мэдээлэл авах буланг шинээр бий болгон ашиглаж байна.

Зам, тээврийн салбарын нэгдсэн платформд нэгдэж, компанийн хүний нөөцийн дата, өгөгдлийг оруулж, цаашдын үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн.

## Архив, албан хэрэг хөтлөлт

Монгол Улсад мөрдөгдөж буй архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, дүрэм, журмын дагуу баримт бичгийн эргэлт, эмх цэгц, соёлыг сайжруулах, байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, шуурхай байдлыг хангаж ажиллаж, 2021 онд хөтлөгдсөн байгууллагын 21 нэр төрлийн 41 хавтас, 6544 хуудас бүхий баримт бичгийг архивын зааврын дагуу хадгаламжийн нэгж болгон архивлаж, цахим мэдээллийн сан болгов.



## Бусад ажлын хүрээнд




Удирдлагын академиас 2022 оны 09 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг сурталчлан таниулах цахим-танхим-цахим сургалтад компанийн 3 удирдах ажилтныг хамруулж, 2021 оны 10 дугаар сарын 21, 11 дүгээр сарын 22-ний өдөр Чингис хаан музей, Соёлын төв өргөөнд зохион байгуулсан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй хийх уулзалт, ярилцлагад 3 ажилтныг, 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан "Төсөв-2023" олон нийтийн хэлэлцүүлэгт 1 ажилтныг тус тус оролцуулав

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

### ТЭР БУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

**300** мод

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр" -ийн хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 15-ний өдөр "Чингис хаан" олон улсын нисэх буудлын Хүндэт зочны үйлчилгээний танхимын гадна талбайд тарьсан модыг услах, арчлах, цэвэрлэгээ явуулах ажлыг зохион байгуулж, компанийн нийт ажилчдыг идэвхтэй хамрууллаа.



Ажилтан нарын идэвх, санаачилгыг өрнүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ууланд алхах, спорт зааланд сагс, волейбол тоглох, уавэр үзэх ажлыг төсөв, зардалгүйгээр сар тутам зохион байгуулж, тэдний чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүллээ.






Зам, тээврийн салбарын хэмжээнд зохион байгуулсан 2022 оны аварга шалгаруулах сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд компанийн баг, тамирчид амжилттай оролцлоо.

### НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

"НУБИЭ"ХХК-иас зохион байгуулсан охин Г.Маралмаад туслах "Хандивын аян"-д нэгдэж, мөнгөн тусламжийг олгох ажлыг зохион байгуулав.

Хүндэт зочны үйлчилгээний албаны үйлчилгээний туслах ажилтны орон тоонд Төв аймгийн Зуунмод сумын 2 иргэнийг томилон ажиллуулж байна.

### ҮР ДҮН

*Хууль тогтоомж, тушаал, шийдвэрийн бүрэн хэрэгжиж, компанийн засаглалын үйл ажиллагаа сайжирсан.*

***Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэлээ.***

*ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР*

Төрийн болон орон нутгийн өмчит болон оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашигт хийх гүйцэтгэлийн аудитын ажлын хүрээнд компанийн **2019-2021** оны үйл ажиллагааны болон санхүүгийн баримт бичиг, үр дүнг хянуулж бүрэн хамрагдсан.

*"ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ" ХХК*

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд компанийн **2021** оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн аудитыг хийлгэж, **"Зөрчилгүй"** дүгнэлт авсан.

**2019, 2020, 2021 он**

**"Зөрчилгүй"**

Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн явцын аудитыг 09 дүгээр сараас хийлгэж байна.

Компанийн **2022** оны бараа, материалын тооллогыг 1 удаа, үндсэн хөрөнгийн тооллогыг 2 удаа явууллаа.




**Үндсэн хөрөнгө**

**8** нэр төрөл

**252** ширхэг

**787,293,193** төгрөг

Эд хөрөнгийн хариуцлагын гэрээг **2** ажилтантай байгуулж, хэрэгжилтийг хангуулав.

Компанийн эзэмшлийн **3** тээврийн хэрэгслийг "Монре даатгал" ХХК-ийн эд хөрөнгийн болон хариуцлагын даатгалд бүрэн хамруулав.

## Санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд



Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоол, Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/93 тоот тушаал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны А-1/947 дугаар албан бичгээр ирүүлсэн заавар чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж, зардал хэмнэн, зайлшгүй шаардлагатайгаас бусад хөрөнгө оруулалтыг зогсоон компанийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

/ хүлээгдэж буй гүйцэтгэлээр –ХБГ /

| Үзүүлэлт | Нийт зардал | Хөрөнгө оруулалт |
|---|---|---|
| Төлөвлөгөө | 1.7 тэрбум.төг | 107.9 сая.төг |
| Тодотгол | 1.2 тэрбум.төг | 22.4 сая.төг |
| ХБГ | 1.19 тэрбум.төг | 12.4 сая.төг |
| Хэмнэлт % | 30% | 89% |

Компани 2022 онд Засгийн газрын санхүүжилт 1.35 тэрбум төгрөг, "Хүндэт зочны танхим"-ын үйлчилгээний орлого 496.0 сая төгрөг, бусад орлого 5.0 сая төгрөг, нийт 1.85 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, үйл ажиллагааны зардал 1.7 тэрбум төгрөг, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 968.4 сая төгрөг, Хүндэт зочны танхим"-ын үйлчилгээний зардалд 707.3 сая төгрөгийг төлөвлөж Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулсан.

Засгийн газрын санхүүжилтийн /ИНЕГ/ орлого 1.35 тэрбум төгрөгийг авах боломжгүй болсон, Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэн шалтгаанаар нийт зардлыг 1.2 тэрбум, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардал 704.2 сая төгрөг, "Хүндэт зочны танхим"-ын үйл ажиллагааны зардал 514.4 сая төгрөг болгож бууруулан, **зардлыг 30 хувиар хэмнэж** жилийн төсөвт тодотгол хийсэн.

Хүлээгдэж буй гүйцэтгэлийн дүнгээр нийт үйл ажиллагааны зардал 1,196 сая төгрөг, үүнээс үндсэн үйл ажиллагааны зардалд 695.0 сая төгрөг, 'Хүндэт зочны танхим"-ын үйл ажиллагааны зардалд 501.7 сая төгрөгийг байна

## Орлого

| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|
| Застийн газрын санхүүжилт | 1,350.0 сая төгрөг | 0 |
| ХЗТ-ын орлого | 496 сая төгрөг | 700 сая төгрөг |
| Бусад орлого | 5 сая төгрөг | 9 сая төгрөг |

"Хүндэт зочны танхим"-ын орлогын төлөвлөгөөг 496 сая төгрөгөөс 700 сая төгрөг, бусад орлогын төлөвлөгөөг 5 сая төгрөгөөс 9 сая төгрөг болгон нэмэгдүүлж, нийт орлогыг 43 хувиар өсгөсөн.

## Улсын төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн нийт дүн

*Хүлээгдэж буй гүйцэтгэлээр*

- ААНОАТ, Бусад: 2 сая төгрөг
- НӨАТ: 39.4 сая төгрөг
- ХХОАТ: 51.3 сая төгрөг
- НДШ: 157.2 сая төгрөг
- Нийт: 249,9 сая төгрөг

2022 онд ААНОАТ ба бусад татварт 2.0 сая төгрөг, НӨАТ-т 39.4 сая төгрөг, ХХОАТ-т 51.3 сая төгрөг, НДШ-д 157.2 сая төгрөг, нийт **249.9 сая төгрөгийг Улсын төсөвт оруулж**, татвар төлбөр төлөх үүргээ зөрчилгүй догoлдолгүй биелүүлсэн.

## ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮГИЙН ҮР ДҮН / Хүлээгдэж буй гүйцэтгэлээр/

| | Нийт зардал 1,773.0 сая.төг | Хөрөнгө оруулалт 107.9 сая.төг | Өөрийн эх үүсвэрийн орлого 501 сая.төг |
|---|---|---|---|
| Хэмнэсэн хувь | - 30 % | - 89 % | +42 % |
| Хэмнэсэн төгрөг | 536.3 сая.төг | 95.5 сая.төг | 208 сая.төг |

## Санхүүгийн тайлагнал

Тайлант жилийн санхүүгийн тайлан, татварын тайлан, холбогдох бусад тайлан, мэдээллийг тухай бүрт, хуулийн хугацаанд нь бэлтгэн тайлагнаж, баталгаажуулж ажиллаж байна. Санхүүгийн үйл ажиллагааг тайлагнах холбогдох хууль журамд заасан үүргээ зөрчил, доголдолгүй биелүүлсэн.

Шилэн дансны тухай хууль, журмын дагуу компанийн санхүүгийн үйл ажиллагаа нийтэд, ил тод мэдээлэх үүргээ зөрчилгүй, бүрэн биелүүлэн ажиллаж байна.

**Хэрэгжилт 100 %**




**Шилэн дансны мэдээлэл :**

**/Хугацаа: жилээр -5, хагас жилээр-3, улирлаар- 1, сараар-3, тухай бүр-10/**
**Тайлант оны нийт мэдээллийн тоо: 154**

**Худалдан авах ажиллагааны мэдээлэл 1**

**Санхүүгийн тайлан /улирал бүр/ 4**

**Татварын тайлангууд /улирал бүр/ 4**

**НӨАТ–ын тайлан /сар бүр/ 12**

## Санхүү нягтлан бодох бүртгэлийн бусад ажил үүрэг

Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандарт, хууль журмын дагуу зөрчил, дутагдалгүй бүртгэж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа зохион байгуулан ажилласан.

Ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож олгосон.

Худалдан авалт, болон бусад арга хэмжээг хууль журмын дагуу явуулж, тайлагнасан.

Харилцагчтай хийх төлбөр тооцооны үүргийг хугацаанд нь гүйцэтгэх, тооцоо нийлэх, хуримтлагдсан өр авлага үүсгээгүй.

Компанийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих зэрэг нягтлан бодох бүртгэлийн өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн хэтлэн явуулсан.

**ҮР ДҮН**

**Компанийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг сахиж, зайлшгүй шаардлагатайгаас бусад хөрөнгө оруулалтыг хойшлуулж, тэвчиж болох зардлыг хасаж, бууруулж хэмнэлтийн горимоор ажилласны үр дүнд зардлыг 30 хувь бууруулж, хөрөнгө оруулалтыг 89 хувь хэмнэв.**

## 2022 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

| № | Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 Оны гүйцэтгэл | 2022 Он | | 2023 оны төлөвлөгөө | Харьцуулалт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | ХБГүйцэтгэл | | 2023төл/ 2022ХБГ | 2023төл- 2022ХБГ |
| 1 | Бүтээгдэхүүн үйлдвэрлэл | | | | | | | |
| | а/ Гол нэр төрлөөр | бнет | | | | | | |
| | б/ Үнийн дүнгээр | мян.төг | | | | | | |
| 2 | **Нийт орлого** | мян.төг | 1,192,090.60 | 709,000.0 | 709,000.00 | 769,622 | 109% | 60,622 |
| Үүнээс | а/ Засгийн газрын санхүүжилт | мян.төг | 949,262.80 | | | 0 | | 0 |
| | б/ Хүндэт зочны танхимын орлого | мян.төг | 21,490.60 | 9,000.00 | 9,000.00 | 10,000 | 111% | 1,000 |
| | в/ Хүүгийн болон бусад орлого | мян.төг | 221337.2 | 700,000.00 | 700,000.00 | 759,622 | 109% | 59,622 |
| 3 | **Нийт зардал** | мян.төг | 790,221.50 | 1,218,590.30 | 1,196,692.00 | 1,972,516 | 165% | 775,824 |
| | Үүнээс удирдлагын зардал | мян.төг | 540,187.10 | 704,174.60 | 695,020.00 | 1,062,386 | 153% | 367,366 |
| 4 | **Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/** | мян.төг | 401,869.10 | -509,590.30 | -487,692.00 | -1,202,894 | 247% | -715,202 |
| 5 | **Цэвэр ашиг /алдагдал/** | мян.төг | 401,869.10 | -509,590.30 | -487,692.00 | -1,202,894 | 247% | -715,202 |
| 6 | **Төсөвт төлбөрт нийт дүн** | мян.төг | 193,371.30 | 260,892.20 | 193,371.30 | 381,344 | 197% | 187,972 |
| | а/ Орлогын татвар | мян.төг | 40,502.10 | 1,000.00 | 1,000.00 | | 0% | -1,000 |
| | б/ НӨАТ | мян.төг | 11718.7 | 39425.7 | 39,425.70 | 39,360 | 100% | -66 |
| | в/ НДШ | мян.төг | 104,291.60 | 160,370.20 | 157,216.50 | 263,204 | 167% | 106,088 |
| | г/ Хүн амын орлогын татвар | мян.төг | 36,630.70 | 59,440.90 | 51,313.90 | 77,980 | 152% | 26,666 |
| | д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар | мян.төг | | | | | | 0 |
| | е/ Гаалийн татвар | мян.төг | | | | | | 0 |
| | ё/ Тээврийн хэрэгслийн татвар | мян.төг | 228.2 | 453.1 | 453.1 | 700 | 154% | 247 |
| | ж/ Бусад | мян.төг | | 562.3 | 562.3 | | | -562 |
| 7 | **Төрийн өмчийн ногдол ашиг** | мян.төг | 36135 | - | | | | 0 |
| 8 | Нийт ажиллагсдын тоо | хүн | 27 | 41 | 41 | 44 | 107% | 3 |
| 9 | Нийт цалингийн сан | мян.төг | 441,938.00 | 668,209.20 | 655,068.60 | 1,097,100 | 167% | 442,031 |
| 10 | Нэг ажилтны дундаж цалин | мян.төг | 1,416.50 | 1,358.10 | 1,331.40 | 2,078 | 156% | 746 |
| 11 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төг | 0.7 | 1.7 | 1.7 | 2.5 | | |
| 12 | **Хөрөнгө оруулалт** | мян.төг | 399,664.90 | 22,350.00 | 12,350.00 | 346,800.00 | | |
| 13 | Нийт авлага | мян.төг | 13297 | 5000 | 5,000.00 | 15,000.00 | | |
| | Үүнээс: найдваргүй | мян.төг | | | | | | 0 |
| 14 | Нийт өглөг | мян.төг | 42,143.10 | 5,400.00 | 5,400.00 | 1,008,000.00 | | 1,002,600 |
| | Богино хугацаат өр төлбөр | мян.төг | 42,143.10 | 5,400.00 | 5,400.00 | 8,000.00 | | 2,600 |
| | Урт хугацаат өр төлбөр | мян.төг | | | | 1,000,000.00 | | 1,000,000 |

## 2022 ОНЫ ҮР ДҮН, ОЛОЛТ

Нислэг, зорчигчийн тоо өссөн

Туузан дамжуургын өргөтгөл

Төсвийн хамаарал

| Нислэг 3 дахин | Зорчигч 6.7 дахин | 1,1 тэрбум | Зардал 30 % | Хөрөнгө оруулалт 89 % |
|---|---|---|---|---|

Монгол Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт" ХХК-д Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлсэн.

| Орлого | Зардал | Цэвэр ашиг |
|---|---|---|
| • 64,385.9<br>• 2.5 дахин өссөн. | • 46,818.2<br>• 0,01 % өссөн. | • 17,895,8<br>• 1.78 дахин өссөн. |

/сая төгрөгөөр/

### Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөө

- ✓ Компанийн тогтвортой хөгжлийг хангах
- ✓ Хамтарсан хуулийн этгээдийн төрийн мэдлийн 49 хувийн хувьцааг эзэмшигчийн эрх үүргийг холбогдох эрхзүйн хэм хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх
- ✓ Санхүүгийн ил тод байдлыг хангах, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөх
- ✓ Компанийн дотоод зохион байгуулалт, засаглалыг сайжруулах

***Хууль тогтоомж, тушаал, шийдвэр***



Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг 2022 онд амжилттай хэрэгжүүлж ажилласан.

Компанийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг хэрэгжүүлж, хэмнэлттэй ажилласан.

Төрийн хүндэт зочны танхимын үйлчилгээний зүй зохистой менежментийг хэрэгжүүлж, олон жилийн туршид байнгын алдагдалтай ажиллаж байсан тус танхимын үйл ажиллагааг алдагдалгүй, ашигтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж чадсан.

Хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлж, Монголын талын хөрөнгө оруулалтыг оновчтой, зөв зарцуулах хяналтыг байнга тавьж ажилласнаар ашигт ажиллагаа нэмэгдэж, нисэх буудлын үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн.

## Компанийн 2023 оны зорилго, зорилт




Алсын хараа-2050, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хууль тогтоомж, тушаал, шийдвэр, Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;

Хувьцаа эзэмшигчдийн болон Концессын гэрээний хэрэгжилтийг хангуулах, хамтарсан компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, Монголын талын хүртэх ногдол ашгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;




"Чингис хаан" Олон улсын нисэх буудлын бөөгнөрлийг бууруулах, зорчигч үйлчилгээний барилгын бодит тооцоот талбайг бүрэн ашиглах, нисэх буудлын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зохион байгуулалтыг холбогдох байгууллагатай хамтран явуулахад хамтарсан компанид дэмжлэг үзүүлэх;

CHINGGIS KHAAN
INTERNATIONAL AIRPORT

Концессын гэрээний 19 дүгээр зүйлийн дагуу "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын Концессын 15 жилийн хугацаа буюу 2035 он хүртэлх хугацааны Мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллах;

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, компанийн санхүү, мөнгөн урсгалыг үр ашигтай удирдан зохион байгуулах;



Компанийн 2023 оны санхүүжилтийг хамгийн боломжит, өөрт ашигтай арга замаар шийдвэрлэх, өөрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судалж шийдэлд хүрэх.